



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 14 өдөр

Дугаар А/161

Улаанбаатар хот

Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай
дархлаажуулалтын ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/219 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1352 дугаар захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/65 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Багахангай дүүргийн нутаг дэвсгэрийн мал бүхий иргэд, аж ахуй нэгжийн үхэр, хонь, ямаа, гахайг шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтад хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий мал, амьтныг вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлэг үйлчилгээний нэгж "ЦЭФ" трейд ХХК (А.Цэрэндагва)-д, вакцинжуулалт хийгдэх товлосон хугацаанд, малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур, халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатахуун, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталж.

4.Гоц халдварт өвчний дархлаажуулалтад шаардагдах 5,670,600 (таван сая зургаан зуун далан мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Дархлаажуулалтын ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, заавар зөвлөмжийг тухай бүр өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2025 он ажил/захирамж

1225010659

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн
20/64 дугаар захирамжийн хавсралт

МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН
АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	290	2590	751,100.00
2	Тариур	ш	500	400	200,000.00
3	Зүү	ш	500	700	350,000.00
4	Нэг удаагийн маск	ш	100	200	20,000.00
5	Нэг удаагийн малгай	ш	100	200	20,000.00
6	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70,000.00
7	Цэнхэр спирт	л	2	6000	12,000.00
8	Шатахуун А-92 (вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад)	л	250	2590	647,500.00
9	Өдрийн хоол	4 хүн/ 20 өдөр	80	20000	1,600,000.00
Дүн					3,670,600.00

2. Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	20	2,000,000.00
Дүн						2,000,000.00
Нийт						5,670,600.00